## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 154. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 27 | 361 |


### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 155. | Журам батлах тухай | Дугаар 12 | 363 |
| 156. | Мөнгөн шагнал олгох тухай | Дугаар 20 | 368 |
| 157. | Зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай | Дугаар 21 | 385 |
| 158. | Гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай | Дугаар 22 | 387 |
| 159. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 23 | 388 |
| 160. | Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай | Дугаар 24 | 388 |
| 161. | Улсын төсвийн 2013 оны хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг баталгаажуулах тухай | Дугаар 26 | 390 |
| 162. | Хурдан морины бүсийн уралдааны 2014 оны хуваарийг тогтоох тухай | Дугаар 28 | 406 |
| 163. | Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай | Дугаар 29 | 407 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2014 оны 3 дугаар сарын 04-ний өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот |

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, олимп, тив,

дэлхийн спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцох баг, тамирчдыг бэлтгэх үндсийг бий болгох ЗОРИЛГООР,

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нэг. Монгол Улсад өвлийн спортыг хөгжүүлэх, өвлийн спортоор хичээллэхэд таатай орчин, нөхцөлийг бий болгох, өвлийн спортын төрлүүдийг сурталчлан таниулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1/ өвлийн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан, задгай болон битүү барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин газарт бариулах, зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;

2/ерөнхий, мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын хичээлийн сургалтын хөтөлбөрт өвлийн спортын төрлүүдээс тусган, өвлийн улиралд дадал болгон хэвшүүлэх, сурагч оюутны өвлийн спортоор хичээллэх таатай орчин нөхцлөөр хангах, энэ чиглэлээр биеийн тамирын багш нарыг мэргэшүүлэх;

3/үндэсний шигшээ багийн өвлийн спортын олимп, тив, дэлхийн уралдаан, тэмцээнд оролцох төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4/ өвлийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэн уралдаан, тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг, тамирчидтай бэлтгэл хийх, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих;

Хоёр. Зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн талаар Ерөнхийлөгчид болон олон нийтэд жил бүр мэдээлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

Гурав. Өвлийн спортын тамирчдыг ивээн тэтгэх, урамшуулах, өвлийн спортын барилга байгууламж барих, шинэ технологийг нэвтрүүлэх

зэргээр эх орондоо өвлийн спортыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн байгууллагад уриалсугай.

| | |
|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** |
| **Ц.ЭЛБЭГДОРЖ** | **Н.АЛТАНХУЯГ** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2014 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот |

**Журам батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30.1-ийг үндэслэн, Усны тухай хуулийн 28.13-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн хайгуул, судалгааны ажлын зардлыг эргүүлэн төлөх төлбөрийг улсын төсвийн бүрдүүлэлтийн тооцоонд тусгаж байхыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С. Оюун нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

| | |
|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** | **Н.АЛТАНХУЯГ** |
| **БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД** | **С.ОЮУН** |

Засгийн газрын 2014 оны 12 дугаар
тогтоолын хавсралт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР СУДАЛЖ ТОГТООСОН ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦИЙН ЭРЭЛ, ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ ЗАРДЛЫГ УС АШИГЛАГЧААР ЭРГҮҮЛЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

## 1. Нийтлэг үндэслэл

Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул, судалгаа, үнэлгээний бүх шатны ажлын (цаашид “Хайгуулын ажил” гэх) зардлыг ус ашиглагчаар төсөвт эргүүлэн нөхөн төлүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

## 2. Хайгуулын ажлын зардал, төлбөр тооцох үндсэн аргачлал

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг зохих журмаар баталгаажсан, геологийн фонд болон улсын усны мэдээллийн санд хадгалагдаж байгаа тухайн хайгуулын тайланд тусгагдсан зардлыг үндэслэн тогтооно.

2.2. Усны ордын нөхөн төлбөрийг тооцохдоо тухайн ордын батлагдсан усны нөөцийн 1 шоо метр/ хоногт ногдох гэрээ байгуулахаас өмнөх оны түвшинд шилжүүлэн тооцсон зардлын хэмжээг ашиглах усны хэмжээ буюу ус хэрэглээ (м3/хоног)-гээр үржүүлэн тооцно.

$$НТЗ=ХЗ_ш * V_х \qquad (1)$$

НТЗ-нөхөн төлөх зардлын хэмжээ, мян.төгрөг

$ХЗ_ш$- нэг $м^3$/хоног усанд ногдох шинэчлэн тогтоосон зардал, мян. төг/($м^3$/хоног)

$V_х$ - ашиглах усны хэмжээ буюу ус хэрэглээ, $м^3$/хоног

2.3. Нэг $м^3$/хоног усанд ногдох шинэчлэн тогтоосон зардлыг тооцохдоо шинэчлэн тогтоосон нийт зардлыг батлагдсан нөөцийн хэмжээнд хувааж олно.

$$ХЗ_ш=НЗ_ш/V_б \qquad (2)$$

$НЗ_ш$ - нийт шинэчлэн тогтоосон зардал, мян.төгрөг

$V_б$ - батлагдсан нөөцийн хэмжээ, м3/хоног

2.4. Шинэчлэн тогтоосон нийт зардал нь тухайн үеийн хайгуулын зардлыг хайгуулын ажлын үнийн өөрчлөлтийн индексээр үржүүлсэнтэй тэнцүү байна. Гэхдээ хайгуулын ажил хийгдсэн оноос хамааран дараах байдлаар тооцно:

2.4.1. 1991 оноос өмнө усны нөөц тогтоогдсон бол тухайн үеийн хайгуулын зардлыг 1991 оны 1 дүгээр сарын 16-ны үнийн түвшинд дараах томъёо (3)-гоор шилжүүлнэ.

$$НЗ_С^{91}=НЗ_б * К_и \quad (3)$$

$НЗ_с^{91}$ - 1991 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн үнийн түвшинд шилжүүлэн тооцсон хайгуулын нийт суурь зардал, мян.төгрөг

$НЗ_б$ - тухайн оны хайгуулын зардал, мян.төгрөг

$К_и$ - Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар тогтоосон хайгуулын ажлын үнийг өсгөх илтгэлцүүр бөгөөд энэ итгэлцүүр 1.5-тай тэнцүү байна.

2.4.2. нийт шинэчилсэн зардлыг 1991 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн үнийн түвшинд шилжүүлэн тооцсон зардлыг инженер-хайгуулын ажлын үнийн өөрчлөлтийн ерөнхий индексээр үржүүлэн тооцно.

$$НЗ_ш=НЗ_с^{91} * EN \quad (4)$$

$НЗ_с^{91}$ - нэг шоо метр усны ногдох 1991 оны 1-р сарын 16-ны өдрийн үнийн түвшинд шилжүүлэн тооцсон зардал, мян. төгрөг

EN- нөхөн төлбөр тооцох оны үнийн өөрчлөлтийн ерөнхий индекс. (Барилгын (инженер-хайгуулын) ажлын үнийн ерөнхий индексийг жил бүр барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нийтэд зарлан мэдээлнэ)

2.4.3. 1991 оны 1 дүгээр сарын 16-наас хойш нөөц нь тогтоогдсон ордын хайгуулын шинэчилсэн нийт зардлыг дараах томъёо (5)-гоор тодорхойлно.

$$НЗ_ш=НЗ_{с.т} * (EN/EN_{с.т}) \quad (5)$$

$НЗ_{с.т}$-нөөцийг судалгаагаар тогтоосон үеийн хайгуулын зардал, мян. төгрөг

EN - нөхөн төлбөр тооцох оны үнийн өөрчлөлтийн ерөнхий индекс, бутархайгаар илэрхийлсэн хувь

$EN_{с.т}$- нөөцийг судалгаагаар тогтоосон үеийн хайгуулын ажлын үнийн өөрчлөлтийн ерөнхий индекс

3. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

3.1. Ус ашиглагч нь ашиглах усны хэмжээнд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар тооцоолуулж, төлбөрийг улсын төсөвт тушаасны дараа ус ашиглах гэрээ байгуулах хүсэлт гаргана.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд зохих шаардлагад нийцүүлэн биелүүлэх үүрэгтэй.

3.3. Ус ашиглагч ашиглах усны хэмжээг гэрээнд заасны дагуу хатуу барих үүрэгтэй.

3.4. Ус ашиглагч байгууллага үйлчилгээний төлбөрийг усаар хангагч байгууллагаас тогтоосон тарифаар төлнө.

3.5. Ашиглагч нь ус ашиглах эрхээ бусдад шилжүүлэх тохиолдолд тэр тухайгаа эрхийн харилцаа үүсэхээс ажлын 10 хоногийн дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Сав газрын захиргаанд мэдэгдэх бөгөөд шилжүүлэн авч байгаа хуулийн этгээд нь хайгуулын ажлын зардлын төлбөрийн өмнөх гэрээг дүгнэсний дараа шинэчилсэн гэрээ байгуулна.

4. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

4.1. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.1-д заасан гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногт багтаан шийдвэрлэнэ.

4.2. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага усны нөөцийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн усны ордыг ашиглуулах тухай гэрээ байгуулах эрхийг ус хангах байгууллага, аж ахуйн нэгжид олгоно.

5 . Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх түүний биелэлтэд хяналт тавих, тайлагнах

5.1. Нэг усны ордоос нөөцийн хэмжээ, даацад тулгуурлан хэд хэдэн аж ахуйн нэгж ус ашиглаж болох бөгөөд ашиглагч бүртэй орд ашиглах гэрээ байгуулна.

5.2. Гэрээ нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.3. Гэрээнд ашиглах усны хэмжээ, төлбөрийн нийт хэмжээ, хугацаа, жилд төлөх төлбөрийг заавал тусгана.

5.4. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн газрын доорх усны нөөцийн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлбөрийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.5. Аж ахуйн нэгж гэрээнд заасан хэмжээнд ус ашиглаж байгаа эсэхэд Сав газрын захиргаа хяналт тавина.

5.6. Аж ахуйн нэгж нөхөн төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй төлбөрийн дүнгийн 0,1 хувиар алданги тооцно.

5.7. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нөхөн төлбөр төлөх тухай мэдэгдэл, шаардлага авснаас хойш нөхөн төлбөр, алданги төлөөгүй бол ус ашиглуулах зөвшөөрлийг цуцална.

6. Бусад

6.1. Гэрээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

6.2. Гэрээг монгол хэл дээр үйлдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвшөөрөгдсөн гадаад хэл рүү хөрвүүлж албажуулна.

6.3. Унд-ахуйн ус хангамжийн зориулалтаар хайгуул хийж нөөц тогтоосон газрын доорх усны ордыг уул уурхайн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахгүй.

6.4. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж усны нөөц тогтоосон талбайд усны нөөцийн зөвлөлийн зөвшөөрөл, дүгнэлтгүйгээр хайгуул, судалгаа хийхийг хориглоно.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

**Мөнгөн шагнал олгох тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шатрын их мастер, сонирхогчдын шатрын дэлхийн аварга, парабуудлагын дэлхийн цомын аварга, таеквондогийн дэлхийн аварга, боксын Ази тивийн аварга, чөлөөт бөхийн залуучуудын Ази тивийн аварга, чөлөөт бөхийн залуучуудын дэлхийн аварга, чөлөөт бөхийн дэлхийн аварга, чөлөөт бөхийн өсвөр үеийн  дэлхийн аварга, оюутны “Универсиад” наадам, даамын их мастер, Азийн хүүхдийн спортын наадам, байт харвааны Ази тивийн аварга, жиу-жицу бөхийн дэлхийн аварга, 100 буудалт даамын өсвөр үеийн дэлхийн аварга, буудлагын Ази тивийн аварга, самбо бөхийн залуучуудын дэлхийн аварга,самбо бөхийн дэлхийн аварга, самбо бөхийн дэлхийн цомын аварга, жүдо бөхийн өсвөр үеийн Ази тивийн аварга, жүдо бөхийн залуучуудын Ази тивийн аварга, жүдо бөхийн гран-при, жүдо бөхийн гранд-слам, жүдо бөхийн залуучуудын дэлхийн аварга, жүдо бөхийн дэлхийн аварга, жүдо бөхийн өсвөр үеийн дэлхийн аварга, паражүдо бөхийн өсвөр үеийн Ази тивийн наадам, бүстэй барилдааны дэлхийн аварга, ой тогтоолтын насанд хүрэгчид, өсвөр үеийн дэлхийн аварга,таеквондогийн оюутны Ази тивийн аварга, бодибилдингийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга, фитнесийн залуучуудын дэлхийн аварга, пауэрлифтингийн дэлхийн аварга, бодибилдинг боксын дэлхийн аварга, шатрын өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин тэдгээрийн дасгалжуулагчдад хавсралтад заасан хэмжээний мөнгөн шагнал олгосугай.

2. Шагналд зарцуулах 1.229.475.000 (нэг тэрбум хоёр зуун хорин есөн сая дөрвөн зуун далан таван мянган) төгрөгийг 2014 оны спортын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД** — **Ц.ОЮУНГЭРЭЛ**

Засгийн газрын 2014 оны 20 дугаар тогтоолын хавсралт

## ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧДАД НЭГ УДАА ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

| № | Тамирчдын нэрс | хүйс | жин, зай, төрөл | авсан медаль | оролцсон орны тоо | мөнгөн шагналын хэмжээ (сая.төг) | шагналын хувь | Шагналын хэмжээ (сая.төг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. Шатрын их мастер** | | | | | | | | |
| 1. | Баярсайхан Гүндаваа | эр | шатар | Их мастер | | 30.000.000 | 100 | 30.000.000 |
| **2. Сонирхогчдын шатрын насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Румын Улсын Яси хот 2013.4.21)** | | | | | | | | |
| 2. | Баярсайхан Янжинлхам | эм | шатар | алт | 37 | 7.000.000 | 100 | 7.000.000 |
| 3. | Эрдэнэпүрэв Болдоо | эр | шатар | хүрэл | 37 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| **3. Парабуудлагын Дэлхийн цомын аварга (Турк Улсын Анталья хот 2013.05.13-18)** | | | | | | | | |
| 4. | Зандраа Ганбаатар | эр | P1-10 | хүрэл | 11 | зөрүү | | 2.400.000 |
| **4. Таеквондогийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Болгар Улсын Софи хот 2013.7.17-21)** | | | | | | | | |
| 5. | Мөнхцог Мөнхжаргал | эм | хатуу биет | алт | 16 | 4.000.000 | 60 | 2.400.000 |
| 6. | Гантулга Уранбилэг | эм | 45кг | хүрэл | 11 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 7. | Ядамжав  Энхзул | эм | түль | хүрэл | 21 | 2.000.000 | 100 | 2.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Бавуудорж Бишгарав | эр | түль | алт | 29 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| 9. | Цогоо Дэлгэрцэцэг | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 10. | Алтангэрэл Оюун-Эрдэнэ | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 11. | Нэргүй Гэрэлмаа | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 12. | Гантулга Уранбилэг | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 13. | Мөнхцог Мөнхжаргал | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 14. | Сандагдорж Будхүү | эм | баг | мөнгө | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| **5. Боксын насанд хүрэгчдийн Ази тивийн аварга (Йордан Улсын Амман хот 2013.6.30-7.9)** | | | | | | | | |
| 15. | Бариадий Жавхлан | эр | 60кг | хүрэл | 19 | 7.000.000 | 100 | 7.000.000 |
| 16. | Уранчимэг Мөнх-Эрдэнэ | эр | 64кг | мөнгө | 22 | 8.000.000 | 100 | 8.000.000 |
| 17. | Жаргал Отгонжаргал | эр | 69кг | хүрэл | 20 | 7.000.000 | 100 | 7.000.000 |
| **6. Чөлөөт бөхийн залуучуудын Ази тивийн аварга (Тайланд Улсын Пукет хот 2013.6.13-16)** | | | | | | | | |
| 18. | Бүрнээбаатар Нямгэрэл | эм | 63кг | хүрэл | 10 | 3.000.000 | 60 | 1.800.000 |
| 19. | Энхбат Гантуяа | эм | 59кг | мөнгө | 11 | 5.000.000 | 60 | 3.000.000 |
| 20. | Алтанцэцэг Батцэцэг | эм | 55кг | хүрэл | 11 | 3.000.000 | 60 | 1.800.000 |
| **7. Чөлөөт бөхийн залуучуудын Дэлхийн аварга (Болгар Улсын Софи хот 2013.8.13-18)** | | | | | | | | |
| 21. | Батболд Номин | эр | 60кг | мөнгө | 32 | 8.000.000 | 100 | 8.000.000 |
| 22. | Эрхэмбаяр Даваачимэг | эм | 51кг | хүрэл | 18 | 6.000.000 | 60 | 3.600.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23. | Пүрэвдорж Орхон | эм | 55кг | хүрэл | 17 | 6.000.000 | 60 | 3.600.000 |
| 24. | Сүхээ Цэрэнчимэд | эм | 59кг | алт | 22 | 12.000.000 | 60 | 7.200.000 |
| **8. Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Унгар Улсын Будапешт хот 2013.9.16-22)** | | | | | | | | |
| 25. | Ганзориг Мандахнаран | эр | 66кг | хүрэл | 40 | 20.000.000 | 100 | 20.000.000 |
| 26. | Эрдэнэчимэг Сумъяа | эм | 51кг | мөнгө | 23 | 25.000.000 | 60 | 15.000.000 |
| 27. | Тунгалаг Мөнхтуяа | эм | 59кг | хүрэл | 25 | 20.000.000 | 100 | 20.000.000 |
| 28. | Соронзонболд Батцэцэг | эм | 63кг | мөнгө | 28 | 25.000.000 | 100 | 25.000.000 |
| 29. | Очирбат Насанбурмаа | эм | 67кг | хүрэл | 24 | 20.000.000 | 100 | 20.000.000 |
| 30. | Очирбат Бурмаа | эм | 72кг | хүрэл | 24 | 20.000.000 | 100 | 20.000.000 |
| **9. Чөлөөт бөхийн өсвөр үеийн Дэлхийн аварга (Серби Улсын Сержан хот 2013.8.20-25)** | | | | | | | | |
| 31. | Занданбуд Занабазар | эр | 54кг | хүрэл | 23 | 3.000.000 | 60 | 1.800.000 |
| **10. Оюутны “Универсиад” наадам жүдо, самбо, чөлөөт бөх, бокс, бүстэй бөх, буудлага (ОХУ-ын Казань хот 2013.7.6-17)** | | | | | | | | |
| 32. | Бунддорж Жанчивдорж | эр | жүдо 90кг | мөнгө | 24 | 15.000.000 | 60 | 9.000.000 |
| 33. | Чимэддорж Марал-Эрдэнэ | эр | самбо бөх 57кг | мөнгө | 15 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 34. | Жагварал Чанцалдулам | эм | самбо бөх 48кг | хүрэл | 15 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 35. | Төмөрбаатар Амаржаргал | эм | самбо бөх 56кг | хүрэл | 14 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 36. | Отгон Мөнхцэцэг | эм | самбо бөх 72кг | хүрэл | 11 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 37. | Нямхүү Нямтуяа | эм | самбо бөх 80кг | хүрэл | 10 | 10.000.000 | 30 | 3.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38. | Болдпүрэв Сугаржаргал | эр | бүстэй бөх 100кг | алт | 11 | 30.000.000 | 30 | 9.000.000 |
| 39. | Дорж Анар | эр | бүстэй бөх 100кг | мөнгө | 12 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 40. | Мөнхбаяр Отгон-Эрдэнэ | эр | бүстэй бөх 60кг | хүрэл | 11 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 41. | Болдпүрэв Сугаржаргал | эр | бүстэй бөх 100кг | хүрэл | 11 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 42. | Содномсүрэн Энхчимэг | эм | бүстэй бөх 66кг | хүрэл | 9 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 43. | Дашням Мөнхтуяа | эм | бүстэй бөх 76кг | хүрэл | 5 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 44. | Ганзориг Мандахнаран | эр | чөлөөт бөх 66кг | хүрэл | 26 | 10.000.000 | 60 | 6.000.000 |
| 45. | Доржханд Хүдэрбулга | эр | чөлөөт бөх 96кг | хүрэл | 18 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 46. | Эрдэнэчимэг Сумъяа | эм | чөлөөт бөх 51кг | мөнгө | 11 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 47. | Соронзонболд Батцэцэг | эм | чөлөөт бөх 63кг | алт | 16 | 30.000.000 | 30 | 9.000.000 |
| 48. | Очирбат Насанбурмаа | эм | чөлөөт бөх 63кг | мөнгө | 11 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 49. | Чулуунбадрах Нарантуяа | эм | буудлага | мөнгө | баг | 15.000.000 | 50 | 7.500.000 |
| 50. | Ганхуяг Нандинзаяа | эм | буудлага | мөнгө | баг | 15.000.000 | 50 | 7.500.000 |
| 51. | Олзвойбаатар Янжинлхам | эм | буудлага | мөнгө | баг | 15.000.000 | 50 | 7.500.000 |
| 52. | Ганхуяг Нандинзаяа | эм | урт 10м | хүрэл | 27 | 10.000.000 | 100 | 10.000.000 |
| 53. | Хархүү Энхдэлгэр | эр | бокс 52кг | алт | 17 | 30.000.000 | 30 | 9.000.000 |
| 54. | Ганхуяг Ган-Эрдэнэ | эр | бокс 49кг | хүрэл | 12 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 55. | Энхжаргал Идэрхүү | эр | бокс 56кг | хүрэл | 14 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 56. | Доржнямбуу Отгондалай | эр | бокс 60кг | хүрэл | 18 | 10.000.000 | 30 | 3.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57. | Бямба Түвшинбат | эр | бокс 69кг | хүрэл | 20 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 58. | Нармандах Шинэбаяр | эр | бокс 75кг | хүрэл | 19 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| **11. Даамын их мастер** | | | | | | | | |
| 59. | Дэлэг Баттулга | | | | | 30.000.000 | 100 | 30.000.000 |
| 60. | Эрдэнэцогт Мандахнаран | | | | | 30.000.000 | 100 | 30.000.000 |
| **12. Азийн хүүхдийн спортын наадам (БНХАУ-ын Нанжин хот 2013.8.16-21)** | | | | | | | | |
| 61. | Энхбаяр Алтантунгалаг | эм | хөнгөн атлетик | хүрэл | 5 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 62. | Зэмбэ Түшигтөр | эр | жүдо бөх 55кг | хүрэл | 27 | 3.000.000 | 100 | 3.000.000 |
| 63. | Цэрэгбаатар Хулан | эм | жүдо бөх 52кг | хүрэл | 20 | 3.000.000 | 100 | 3.000.000 |
| **13. Байт харвааны насанд хүрэгчдийн Ази тивийн аварга (БНХАУ Тайваны Тайпей хот 2013.11.04)** | | | | | | | | |
| 64. | Жанцан Гантөгс | эр | байт хувь | мөнгө | 9 | 8.000.000 | 30 | 2.400.000 |
| **14. Жиу-Жицу бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (АНУ-ын Лонг Бийч хот 2013.11.01-03)** | | | | | | | | |
| 65. | Сэлэнгэ Энхзаяа | эм | NO-GI | мөнгө | 13 | 5.000.000 | 30 | 1.500.000 |
| 66. | Болдпүрэв Өнөржаргал | эр | NO-GI | хүрэл | 26 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| **15. 100 буудалт даамын өсвөр үеийн Дэлхийн аварга (Беларусь Улсын Орша хот 2013.10.26-11.03)** | | | | | | | | |
| 67. | Ганбат Дүүрэнбилэг | эм | даам | мөнгө | 11 | 2.000.000 | 30 | 600.000 |
| **16. Буудлагын насанд хүрэгчдийн Ази тивийн аварга (Иран Улсын Тегеран хот 2013.10.18-26)** | | | | | | | | |
| 68. | Цогбадрах Мөнхзул | эм | гар буу | алт | 18 | 10.000.000 | 100 | 10.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69. | Төмөрчөдөр Баярцэцэг | эм | баг гар буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 70. | Төмөрчөдөр Баярмаа | эм | баг гар буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 71. | Цогбадрах Мөнхзул | эм | баг гар буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 72. | Чулуунбадрах Нарантуяа | эм | баг урт буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 73. | Олзвойбаатар Янжинлхам | эм | баг урт буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 74. | Ганхуяг Нандинзаяа | эм | баг урт буу | хүрэл | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| **17. Самбо бөхийн залуучуудын Дэлхийн аварга (Грек Улсын Дессалоники хот 2013.10.11-14)** | | | | | | | | |
| 75. | Энхтайван Гантогтох | эр | 48кг | алт | 13 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 76. | Амартүвшин Баяраа | эр | 52кг | алт | 14 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 77. | Бунддорж Энхзул | эм | 56кг | хүрэл | 13 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 78. | Цогтмагнай Мөнхгэрэл | эм | 70кг | хүрэл | 8 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 79. | Адъяахүү Пүрэвсүрэн | эр | 81кг | мөнгө | 18 | 3.000.000 | 30 | 900.000 |
| **Өсвөр үе** | | | | | | | | |
| 80. | Гаадамба Баянмөнх | эр | 74кг | мөнгө | 17 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 81. | Даваасүрэн Аззаяа | эр | 100кг | хүрэл | 8 | 1.000.000 | 30 | 300.000 |
| **18. Самбо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (ОХУ-ын Санктпетрбург хот 2013.11.22-24)** | | | | | | | | |
| 82. | Доржсүрэн Сумъяа | эм | 56кг | алт | 20 | 7.000.000 | 60 | 4.200.000 |
| 83. | Түмэн-Од Баттөгс | эм | 64кг | хүрэл | 14 | 4.000.000 | 30 | 1.200.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84. | Хашбаатар Цагаанбаатар | эр | 74кг | мөнгө | 30 | 5.000.000 | 100 | 5.000.000 |
| 85. | Ууганбаатар Отгонбаатар | эр | 82кг | хүрэл | 35 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| 86. | Төмөрхүлэг Даваадорж | эр | 68кг | хүрэл | 31 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| 87. | Баасанпүрэв Дамланпүрэв | эр | 62кг | хүрэл | 18 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 88. | Мөнхбат Баярсайхан | эр | 52кг | мөнгө | 14 | 5.000.000 | 30 | 1.500.000 |
| **19. Самбо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн цомын аварга (ОХУ-ын Москва хот 2013.11.19-23)** | | | | | | | | |
| 89. | Түмэн-Од Баттөгс | эм | 64кг | алт | 6 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| **20. Жүдо бөхийн өсвөр үеийн Ази тивийн аварга (БНХАУ-ын Хайнан хот 2013.12.12-13)** | | | | | | | | |
| 90. | Эрдэнэхүү Мөнхжаргал | эр | 81кг | алт | 11 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 91. | Лхагватогоо Энхрийлэн | эм | 48кг | мөнгө | 10 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 92. | Цэрэгбаатар Хулан | эм | 57кг | мөнгө | 9 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 93. | Баттулга Хонгорзул | эм | 70кг | мөнгө | 4 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 94. | Цэнд-Очир Цогтбаатар | эр | 60кг | мөнгө | 14 | 2,000,000 | 60 | 1,200,000 |
| 95. | Батсүх Алтанцэцэг | эм | 52кг | хүрэл | 9 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 96. | Мөнхбат Даваасүрэн | эм | 63кг | хүрэл | 7 | 1.000.000 | 30 | 300.000 |
| **21. Жүдо бөхийн залуучуудын Ази тивийн аварга (БНХАУ-ын Хайнан хот 2013.12.12-13)** | | | | | | | | |
| 97. | Ганбаатар Наранцэцэг | эм | 44кг | мөнгө | 7 | 5.000.000 | 30 | 1.500.000 |
| 98. | Болд Ганхайч | эм | 63кг | алт | 7 | 7.000.000 | 30 | 2.100.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 99. | Өлзийбаяр Дүүрэнбаяр | эр | 100кг | алт | 9 | 7.000.000 | 30 | 2.100.000 |
| **22. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Гран-При (АНУ-ын Миами хот 2013.06.15-16)** | | | | | | | | |
| 100. | Батцэцэг Батгэрэл | эр | 66кг | хүрэл | 19 | 10.000.000 | 60 | 6.000.000 |
| 101. | Адъяасамбуу Цолмон | эм | 52кг | хүрэл | 17 | 10.000.000 | 100 | 10.000.000 |
| 102. | Ган Түвшинжаргал | эр | 81кг | хүрэл | 17 | 10.000.000 | 60 | 6.000.000 |
| 103. | Болдпүрэв Сугаржаргал | эр | 100кг | хүрэл | 12 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| **23. “Чингис хаан 2013” жүдо бөхийн Гран-При(Монгол Улсын Улаанбаатар хот 2013.07.13-14)** | | | | | | | | |
| 104. | Цэнд-Аюуш Цэрэннадмид | эм | 63кг | алт | 4 | 20.000.000 | 30 | 6.000.000 |
| 105. | Цэнд-Аюуш Наранжаргал | эм | 70кг | мөнгө | 6 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 106. | Алтай Батзул | эм | 57кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 107. | Базаррагчаа Нарантуяа | эм | 57кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 108. | Доржсүрэн Сумъяа | эм | 57кг | алт | 7 | 20.000.000 | 30 | 6.000.000 |
| 109. | Баттулга Мөнхтуяа | эм | 78кг | алт | 4 | 20.000.000 | 30 | 6.000.000 |
| 110. | Санжаасүрэн Мияарагчаа | эр | 66кг | алт | 9 | 20.000.000 | 30 | 6.000.000 |
| 111. | Отгонбаатар Уганбаатар | эр | 81кг | мөнгө | 8 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 112. | Галбадрах Отгонцэцэг | эм | 48кг | мөнгө | 3 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 113. | Одхүү Жавзмаа | эм | 78кг | мөнгө | 4 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| 114. | Балдорж Мөнгөнчимэг | эм | 63кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 115. | Магсаржав Долгоржав | эм | 48кг | хүрэл | 3 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 116. | Төрбат Баасанжав | эм | 78кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 117. | Чинтогтох Аззаяа | эм | 52кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 118. | Балжинням Бат-Эрдэнэ | эм | 52кг | хүрэл | 4 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 119. | Лхагвасүрэн Отгонбаатар | эр | 90кг | хүрэл | 10 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| 120. | Өлзийбаяр Дүүрэнбаяр | эр | 100кг | хүрэл | 3 | 10.000.000 | 30 | 3.000.000 |
| **24. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Гранд-Слам (Япон Улсын Токио хот 2013.11.29-30)** | | | | | | | | |
| 121. | Найдан Түвшинбаяр | эр | 100кг | хүрэл | 18 | 10.000.000 | 60 | 6.000.000 |
| 122. | Мөнхбат Уранцэцэг | эм | 48кг | мөнгө | 13 | 15.000.000 | 60 | 9.000.000 |
| **25. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Гран-При (БНСУ-ын Чэжу хот 2013.12.05-06)** | | | | | | | | |
| 123. | Мөнхбаатар Бундмаа | эм | 52кг | алт | 9 | 20.000.000 | 30 | 6.000.000 |
| **26. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Гранд-Слам (БНАУлсын Баку хот 2013.5.4-5)** | | | | | | | | |
| 124. | Эрдэнэбилэг Энхбат | эр | 100кг | мөнгө | 10 | 15.000.000 | 30 | 4.500.000 |
| **27. Жүдо бөхийн залуучуудын Дэлхийн аварга (Словени Улсын Любляна хот 2013.10.23-26)** | | | | | | | | |
| 125. | Балдорж Мөнгөнчимэг | эм | 63кг | хүрэл | 28 | 6.000.000 | 100 | 6.000.000 |
| 126. | Өлзийбаяр Дүүрэнбаяр | эр | 100кг | мөнгө | 23 | 8.000.000 | 60 | 4.800.000 |
| **28. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Бразил Улсын Рио-де Жанеро хот 2013.08.26-31)** | | | | | | | | |
| 127. | Мөнхбат Уранцэцэг | эм | 48кг | алт | 28 | 40.000.000 | 100 | 40.000.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 128. | Дашдаваа Амартүвшин | эр | 60кг | мөнгө | 55 | 25.000.000 | 100 | 25.000.000 |
| **29. Жүдо бөхийн өсвөр үеийн Дэлхийн аварга (АНУ-ын Миами хот 2013.8.8-11)** | | | | | | | | |
| 129. | Баяраа Амартүвшин | эр | 50кг | хүрэл | 29 | 3.000.000 | 60 | 1.800.000 |
| 130. | Цэнд-Очир Цогтбаатар | эр | 60кг | хүрэл | 23 | 3.000.000 | 60 | 1.800.000 |
| **30. Паражүдо бөхийн өсвөр үеийн Ази тивийн наадам (Малайз Улсын Куала-Лумпур хот 2013.10.24)** | | | | | | | | |
| 131. | Зэвэг Хосбаяр | эр | 60кг | мөнгө | 6 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| **31. Бүстэй барилдааны насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Беларусь Улсын Минск хот 2013.12.19-22)** | | | | | | | | |
| 132. | Болдпүрэв Сугаржаргал | эр | 100кг | алт | 15 | 4.000.000 | 60 | 2.400.000 |
| **32. Ой тогтоолтын насанд хүрэгчид, өсвөр үеийн Дэлхийн аварга (Англи Улсын Лондон хот 2013.11.30-12.02)** | | | | | | | | |
| 133. | Өлзийхутаг Сэнгэсамдан | эр | хөзөр 1 цаг | хүрэл | 32 | 2.000.000 | 100 | 2.000.000 |
| 134. | Сайханбаяр Цогбадрах | эр | дуут цифр | алт | 32 | 4.000.000 | 100 | 4.000.000 |
| 135. | Сайханбаяр Цогбадрах | эр | 5 минут тоо | мөнгө | 32 | 3.000.000 | 100 | 3.000.000 |
| 136. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | 1цаг тоо | мөнгө | 32 | 1.000.000 | 100 | 1.000.000 |
| **Өсвөр үе** | | | | | | | | |
| 137. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | хөзөр 1 цаг | алт | 17 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 138. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | дуут цифр | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 139. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | 5 минут тоо | алт | 17 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 140. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | үгс | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 141. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | хийсвэр зураг | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 142. | Бат-Эрдэнэ  Намуунтуул | эм | 1 цаг тоо | алт | 17 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 143. | Бат-Эрдэнэ Намуунтуул | эм | 2-тын тоолол | алт | 17 | 2.000.000 | 60 | 1.200.000 |
| 144. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | хөзөр 1 цаг | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 145. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | түүхэн үйл явдал | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 146. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | 5 минут тоо | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 147. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | 1 цаг тоо | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 148. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | 2-тын тоолол | мөнгө | 17 | 1.000.000 | 60 | 600.000 |
| 149. | Цогоо Бат-Эрдэнэ | эр | дуут цифр | хүрэл | 17 | 500.000 | 60 | 300.000 |
| 150. | Зоригтбаатар Цэцэгзул | эм | хөзөр хурд | хүрэл | 17 | 500.000 | 60 | 300.000 |
| 151. | Ганзориг Тэмүүлэн | эр | 2-тын тоолол | алт | 12 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 152. | Ганзориг Тэмүүлэн | эр | хийсвэр зураг | алт | 12 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 153. | Ганзориг Тэмүүлэн | эр | хөзөр 1 цаг | алт | 12 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 154. | Ганзориг Тэмүүлэн | эр | нэр зүс царай | хүрэл | 12 | 500.000 | 30 | 150.000 |
| 155. | Ганзориг Тэмүүлэн | эр | түүхэн үйл явдал | мөнгө | 12 | 1.000.000 | 30 | 300.000 |
| **33. Таеквондогийн оюутны Ази тивийн аварга (БНСУ-ын Чеон Ян хот 2013.10.30-11.4)** | | | | | | | | |
| 156. | Молом Түмэнбаяр | эр | 58кг | алт | 6 | 7.000.000 | 30 | 2.100.000 |
| 157. | Мөнхболд Мягмарбаяр | эр | 68кг | алт | 8 | 7.000.000 | 30 | 2.100.000 |
| 158. | Энхбат Мөнхбуян | эр | 74кг | алт | 3 | 7.000.000 | 30 | 2.100.000 |
| 159. | Самдансүрэн Янжинлхам | эм | 49кг | мөнгө | 6 | 5.000.000 | 30 | 1.500.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 160. | Батмөнх Түвшинжаргал | эр | 87кг | мөнгө | 3 | 5.000.000 | 30 | 1.500.000 |
| 161. | Пүрэвжав Тэмүүжин | эр | 63кг | хүрэл | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 162. | Далхсүрэн Энхтүвшин | эр | 68кг | хүрэл | 6 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 163. | Нармандах Энхдөл | эр | 87кг | хүрэл | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 164. | Лхагвасүрэн Мөнхгэрэл | эм | 67кг | хүрэл | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 165. | Молом Түмэнбаяр | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 166. | Мөнхболд Мягмарбаяр | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 167. | Пүрэвжав Тэмүүжин | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 168. | Батмөнх Түвшинжаргал | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 169. | Нармандах Энхдөл | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 170. | Далхсүрэн Энхтүвшин | эр | баг | алт | 3 | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| **34. Бодибилдинг Фитнесийн Залуучуудын Дэлхийн аварга (Монгол Улсын Улаанбаатар хот 2013.10.24-27)** | | | | | | | | |
| 171. | Болдбаатар Дэлгэрсайхан | эм | фитнес | хүрэл | 4 | 2.000.000 | 30 | 600.000 |
| **35. Пауэрлифтингийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (БНЧУ-ын Прага хот 2013.10.26-11.04)** | | | | | | | | |
| **Залуучуудын ангилал** | | | | | | | | |
| 172. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлтэй таталт | алт | 1 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 173. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлгүй нийлбэр | алт | 2 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 174. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлтэй нийлбэр | алт | 2 | 3.000.000 | 30 | 900.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 175. | Авдалхамид Бердмурат | эр | 75кг хэрэглэлтэй таталт | алт | 6 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 176. | Авдалхамид Бердмурат | эр | 75кг хэрэглэлгүй нийлбэр | алт | 1 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 177. | Авдалхамид Бердмурат | эр | 75кг хэрэглэлтэй нийлбэр | алт | 1 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 178. | Рэнцэнцэдэв Шинэбаяр | эр | 90кг хэрэглэлгүй шахалт | алт | 2 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 179. | Рэнцэнцэдэв Шинэбаяр | эр | 90кг хэрэглэлтэй шахалт | хүрэл | 2 | 1.000.000 | 30 | 300.000 |
| 180. | Рэнцэнцэдэв Шинэбаяр | эр | 90кг хэрэглэлтэй нийлбэр | мөнгө | 5 | 2.000.000 | 30 | 600.000 |
| **Насанд хүрэгчид** | | | | | | | | |
| 181. | Дарханбаатар Ичинноров | эм | 75кг хэрэглэлтэй нийлбэр | мөнгө | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 182. | Дарханбаатар Ичинноров | эм | 75кг хэрэглэлтэй нийлбэр | алт | 2 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 183. | Дарханбаатар Ичинноров | эм | 75кг хэрэглэлгүй шахалт | мөнгө | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 184. | Дарханбаатар Ичинноров | эм | 75кг хэрэглэл тэй шахалт | алт | 4 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 185. | Төмөрөө Даваа | эм | 60кг хэрэглэлтэй нийлбэр | алт | 4 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 186. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлтэй нийлбэр | хүрэл | 5 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 187. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлтэй нийлбэр | алт | 2 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 188. | Гонгор Отгонтуяа | эм | 67.5кг хэрэглэлгүй нийлбэр | мөнгө | 6 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 189. | Дондог Цогзолдорж | эр | 110кг хэрэглэлтэй таталт | мөнгө | 3 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 190. | Чулуудай Баясгалан | эр | 140кг хэрэглэлтэй суулт | мөнгө | 4 | 2.000.000 | 30 | 600.000 |
| 191. | Банзрагч Дэлгэрхишиг | эр | 100кг хэрэглэлтэй нийлбэр | мөнгө | 8 | 3.000.000 | 30 | 900.000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 192. | Эрдэнэбилэг Ууганбаяр | эр | 125кг хувцастай нийлбэр | алт | 4 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 193. | Эрдэнэбилэг Ууганбаяр | эр | 125кг суулт | алт | 3 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 194. | Лхамжав Мөнхбаяр | эр | 90кг шахалт | мөнгө | 4 | 3.000.000 | 30 | 900.000 |
| 195. | Батгэрэл Баярбаатар | эр | 67.5кг шахалт | алт | 2 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| 196. | Батгэрэл Баярбаатар | эр | 67.5кг нийлбэр | алт | 2 | 4.000.000 | 30 | 1.200.000 |
| **36. Бодибилдингийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга (Унгар Улсын Будапешт хот 2013.11.13-17)** | | | | | | | | |
| 197. | Баярсайхан Оюунгэрэл | эм | 160 см модел | хүрэл | 6 | 2.000.000 | 30 | 600.000 |
| **37. Боксын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Казакстан Улсын Алма-Ата хот 2013.10.13-26)** | | | | | | | | |
| 198. | Уранчимэг Мөнх-Эрдэнэ | эр | 64кг | хүрэл | 55 | 20.000.000 | 100 | 20.000.000 |
| **38. Шатрын өсвөр үеийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Эмират Улсын Аль-Айн хот 2013.12.16-29)** | | | | | | | | |
| 199. | Бат-Эрдэнэ Мөнгөнзул | эм | Шатар | мөнгө | 55 | 2.000.000 | 100 | 2.000.000 |
| | **39.Дасгалжуулагчид** | | | | | | | |
| 200. | Намжил Чинбат (шатар) | | | | | 30.000.000 | 50 | 15.000.000 |
| 201. | Баярсайхан Мөнхөө (шатар) | | | | | 7.000.000 | 50 | 3.500.000 |
| 202. | Дашзэвгэ Шаравдорж (шатар) | | | | | 4.000.000 | 50 | 2.000.000 |
| 203. | Вашлий Ганцоож (парабуудлага) | | | | | 2.400.000 | 50 | 1.200.000 |
| 204. | Батсуурь Мөнх-Оргил (таеквондо) | | | | | 18.000.000 | 50 | 9.000.000 |
| 205. | Батсайхан Идэрсайхан (чөлөөт) | | | | | 1.800.000 | 50 | 900.000 |
| 206. | Зэвэг Дүвчин (чөлөөт) | | | | | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 207. | Цэнд Баярсайхан (чөлөөт) | | | | | 900.000 | 50 | 450.000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 208. | Оюунбилэг Пүрэвбаатар (чөлөөт) | 8.000.000 | 50 | 4.000.000 |
| 209. | Түмэндэмбэрэл Сүхбаатар (чөлөөт) | 3.600.000 | 50 | 1.800.000 |
| 210. | Цэрэнбаатар Хосбаяр (чөлөөт) | 30.800.000 | 50 | 15.400.000 |
| 211. | Зэвэг Дүвчин (чөлөөт) | 40.000.000 | 50 | 20.000.000 |
| 212. | Чүлтэмсүрэн Раднаабазар (чөлөөт) | 20.000.000 | 50 | 10.000.000 |
| 213. | Түмэндэмбэрэл Сүхбаатар (чөлөөт) | 40.000.000 | 50 | 20.000.000 |
| 214. | Цогбадрах Гантөгс (чөлөөт) | 1.800.000 | 50 | 900.000 |
| 215. | Буяндэлгэр Батбаяр (чөлөөт) | 18.000.000 | 50 | 9.000.000 |
| 216. | Цэрэнбаатар Цогтбаяр (чөлөөт) | 9.000.000 | 50 | 4.500.000 |
| 217. | Дашгомбо Баттулга (жүдо бөх) | 190.500.000 | 50 | 95.250.000 |
| 218. | Дашжамц Энхбаатар (жүдо бөх) | 7.200.000 | 50 | 3.600.000 |
| 219. | Цэдэн-Иш Шийрэв (жүдо бөх) | 5.100.000 | 50 | 2.550.000 |
| 220. | Шархүү Цэвэлмаа (жүдо бөх) | 8.100.000 | 50 | 4.050.000 |
| 221. | Дашхүү Алтантуяа (жүдо бөх) | 300.000 | 50 | 150.000 |
| 222. | Шарав Бат-Орших (жүдо бөх) | 6.900.000 | 50 | 3.450.000 |
| 223. | Зоригт Сүхчулуун (жүдо бөх) | 2.700.000 | 50 | 1.350.000 |
| 224. | Чоёндорж Базарсүрэн (жүдо бөх) | 3.000.000 | 50 | 1.500.000 |
| 225. | Гүрсэд Энхбаяр (жүдо бөх) | 1.800.000 | 50 | 900.000 |
| 226. | Жамсранжав Баярсайхан (самбо) | 21.900.000 | 50 | 10.950.000 |
| 227. | Хүрэлдорж Батхишиг (самбо) | 22.300.000 | 50 | 11.150.000 |
| 228. | Гантөмөр Дашдаваа (бүстэй бөх) | 27.900.000 | 50 | 13.950.000 |
| 229. | Сангидорж Адилбиш (буудлага) | 11.000.000 | 50 | 5.500.000 |
| 230. | Жанчивдорж Ганхуяг (буудлага) | 32.000.000 | 50 | 16.000.000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 231. | Цэрэнжав Өлзийбаяр (буудлага) | 17.000.000 | 50 | 8.500.000 |
| 232. | Лхагва Ундралбат (буудлага) | 3.500.000 | 50 | 1.750.000 |
| 233. | Дашзэвэг Ганзориг (бокс) | 24.000.000 | 50 | 12.000.000 |
| 234. | Батбуян Энхтайван (бокс) | 22.000.000 | 50 | 11.000.000 |
| 235. | Гонгоосүрэн Оюунболд (бокс) | 20.000.000 | 50 | 10.000.000 |
| 236. | Чимэддорж Бат-Амгалан (даам) | 30.000.000 | 50 | 15.000.000 |
| 237. | Чимэддорж Бат-Эрдэнэ (даам) | 30.000.000 | 50 | 15.000.000 |
| 238. | Ганболд Бүрэнболд (даам) | 600.000 | 50 | 300.000 |
| 239. | Чулуунбаатар Болдбаатар (хөнгөн атлетик) | 900.000 | 50 | 450.000 |
| 240. | Жавзмаа Нарантуяа (байт харваа) | 2.400.000 | 50 | 1.200.000 |
| 241. | Одсүрэн Болд-Эрдэнэ (жиу жицу) | 5.500.000 | 50 | 2.750.000 |
| 242. | Базаррагчаа Нарантуяа (паражүдо) | 1.200.000 | 50 | 600.000 |
| 243. | Хандсүрэн Хатанбаатар (ой тогтоолт) | 22.450.000 | 50 | 11.225.000 |
| 244. | Наранчимэг Эрдэнэбаатар (таеквондо) | 33.900.000 | 50 | 16.950.000 |
| 245. | Батнасан Батням (бодибилдинг) | 600.000 | 50 | 300.000 |
| 246. | Сосорбарам Жаргалсайхан (пауэрлифтинг) | 23.400.000 | 50 | 11.700.000 |
| 247. | Гансүх Дорж (бодибилдинг) | 600.000 | 50 | 300.000 |
| 248. | Намхай Баттулга (дасгалжуулагч) | 2.000.000 | 50 | 1.000.000 |
| Нийт дүн | | | | 1.229.475.000 |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

**Зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн 2014 оны үйл ажиллагааны төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулан, зардлыг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулан нийтэд мэдээлж байхыг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл" (Ч.Эрдэнэчимэг)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.АЛТАНХУЯГ**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

Засгийн газрын 2014 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

**ХОТ,СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

мян.төг

| Эдийн засгийн ангилал | Дүн |
|---|---|
| Ус, хангамж, ариутгах татуургын зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлого | 482.217.10 |

| Эдийн засгийн ангилал | Дүн |
|---|---|
| Ус, хангамж, ариутгах татуургын зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлого | 482.217.10 |
| Орлогын дүн | 482.217.10 |
| II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 482.117.10 |
| IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 479.017.10 |
| Бараа, үйлчилгээний зардал | 471.552.10 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 284.020.00 |
| Үндсэн цалин | 237.000.00 |
| Нэмэгдэл, урамшил | 23.700.00 |
| Унаа, хоолны хөнгөлөлт | 23.320.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31.242.20 |
| Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл | 25.561.80 |
| Тэтгэврийн даатгал | 19.881.40 |
| Тэтгэмжийн даатгал | 1.420.10 |
| ҮОМШ өвчний даатгал | 2.840.20 |
| Ажилгүйдлийн даатгал | 1.420.10 |
| Байгууллага төлөх ЭМД-ын хураамж | 5.680.40 |
| Бараа, үйлчилгээний бусад зардал | 156.289.90 |
| Бичиг хэрэг | 5.300.00 |
| Тээвэр (шатахуун) | 10.990.10 |
| Шуудан, холбоо | 5.148.00 |
| Дотоод албан томилолт | 8.245.00 |
| Гадаад томилолт (арга хэмжээ) | 11.487.70 |
| Эд хогшил худалдан авах | 28.491.50 |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс | 1.491.50 |
| Программ хангамж | 27.000.00 |
| Урсгал засвар | 3.404.60 |
| Төлбөр хураамж болон бусад зардал | 14.100.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал | 19.243.60 |
| Түрээсийн зардал | 53.655.00 |
| Сургалт, хурал, зөвлөлгөөний зардал | 6.000.00 |
| Сургалт, семинар зохион байгуулах зардал | 6.000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс,төлбөр хураамж | 9.468.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ | 9.468.00 |
| Татаас ба урсгал шилжүүлэг | 7.465.00 |
| Өрх гэрт олгох шилжүүлэг | 2.765.00 |

| | |
|---|---|
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, дэмжлэг | 2.765.00 |
| Нэг удаагийн буцалтгүй тусламж | 2.015.00 |
| Шагнал, урамшил | 750.00 |
| Төлбөр хураамж | 1.200.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 1.200.00 |
| Гадаад шилжүүлэг | 3.500.00 |
| Олон улсын байгууллагын гишүүний татвар | 3.500.00 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3.100.00 |
| Тоног төхөөрөмж: Өөрийн хөрөнгөөр санхүүжих | 3.100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР: | 482.117.10 |
| Өөрийн орлогоос санхүүжих | 482.117.10 |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 |
| АЖИЛЛАГСАД БҮГД | 24 |
| Удирдах ажилтан | 4 |
| Гүйцэтгэх ажилтан | 17 |
| Үйлчлэх ажилтан | 3 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр — Дугаар 22 — Улаанбаатар хот

**Гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг, Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын 4 дэх заалт, 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 1.2.2, 3.1, 7.3.1, 7.3.2, 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Иргэний агаарын тээврийн салбарт ашиглах зорилгоор Замын-Үүдийн боомтоор импортолсон агаарын хөлгийн шатахууны гаалийн албан татварыг “0” (тэг) хувиар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — Н.АЛТАНХУЯГ**

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД — А.ГАНСҮХ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2011 оны 12 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын ерөнхий гэрээ”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны газрын 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XYIII.1.36-д “Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Өлгий-Ховд чиглэлийн авто замын үргэлжлэл хатуу хуучилттай авто зам 189.7 км (Ховд)” гэснийг хассугай.

2. Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Өлгий-Ховд чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгч болон хяналтын зөвлөхийг шалгаруулах ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** — **Н.АЛТАНХУЯГ**

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД** — **А.ГАНСҮХ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

**Автобензин, дизелийн түлшний гааль,**
**онцгой албан татварын тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж ирсэн автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

| № | Хилийн боомтын нэр | Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр) | | |
|---|---|---|---|---|
| | | Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ) | | Дизелийн түлш |
| | | 90 хүртэл | 90 болон түүнээс дээш | |
| 1. | Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга | 0 | 0 | 0 |
| 2. | Ханх, Ульханмайхан | 0 | 0 | 0 |
| 3. | Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг | 30.000 | 0 | 30.000 |

2. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг “1” хувиар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гааль, онцгой албан татварын тухай” Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 236 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2014 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД** **Ч.УЛААН**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Дугаар 26 Улаанбаатар хот

## Улсын төсвийн 2013 оны хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг баталгаажуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 болон Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээний худалдан авах гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд тусгагдаж, тухайн төсвийн жилд санхүүжигдээгүй, гэрээний үлдэгдэл төлбөр бүхий хавсралтад дурдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянасны үндсэн дээр векселиэр баталгаажуулахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Векселиэр баталгаажсан хөрөнгө, векселийн хүүгийн зардлыг 2014 оны улсын төсөвт холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмж тусгахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын 2-т заасны дагуу 2014 оны улсын төсөвт холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмж тусгасан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг вексель эзэмшигчдэд олгохыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны
26 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАГДАЖ, ТУХАЙН ТӨСВИЙН ЖИЛД САНХҮҮЖИГДЭЭГҮЙ, ГЭРЭЭНИЙ ҮЛДЭГДЭЛ ТӨЛБӨР БҮХИЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил | Санхүүжих дүн |
|---|---|---|
| А | Б | |
| **I** | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА** | **87.6** |
| I.1 | Тоног төхөөрөмж: | 87.6 |
| I.1.1 | Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд эд зүйлс урлан бүтээх | 87.6 |
| **XI** | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** | **8,063.2** |
| **XI.1** | **Тагнуулын Ерөнхий Газар** | **760.1** |
| XI.1.1 | Хөрөнгө оруулалт: | 760.1 |
| **XI.3** | **Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар** | **1,757.6** |
| XI.3.1 | Хөрөнгө оруулалт: | 1,757.6 |
| XI.3.1.10 | Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах /аймаг, нийслэл/ | 1,451.8 |
| XI.3.1.18 | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалт | 305.8 |
| **XI.5** | **Шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт** | **5,545.5** |
| XI.5.1 | Хөрөнгө оруулалт: | 5,545.5 |
| XI.5.1.5 | Аймгуудын нэгдсэн оношлогооны төв бий болгох | 5,228.0 |
| XI.5.1.6 | Залуучуудын үйлчилгээний цогцолбор босгох | 317.5 |
| **XII** | **МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД** | **426.1** |
| **XII.1** | **Онцгой байдлын ерөнхий газар** | **23.4** |
| XII.1.1 | Хөрөнгө оруулалт: | 23.4 |
| XII.1.1.8 | Аврах гал унтраах ангийн барилга /Хэнтий, Бэрх/ | 23.4 |
| **XII.3** | **Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв** | **402.7** |
| XII.3.1 | Хөрөнгө оруулалт: | 259.0 |
| XII.3.1.1 | Шалгалт тохируулгын лаборатори байгуулах | 259.0 |
| XII.3.3 | Тоног төхөөрөмж: | 143.7 |
| XII.3.3.1 | Төв, орон нутгийн хэмжил зүйн лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл | 143.7 |
| **XIII** | **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** | **599.7** |
| XIII.1 | Хөрөнгө оруулалт: | 50.0 |

| | | |
|---|---|---|
| XIII.1.4 | С.Зориг агсны нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, дурсгалын цогцолбор /Дорнод, Дашбалбар/ | 50.0 |
| XIII.3 | Тоног төхөөрөмж: | 549.7 |
| XIII.3.6 | Үйлчилгээний автомашин | 49.7 |
| XIII.3.7 | ТЗҮААЭГ-ын харъяа Автобаазын парк шинэчлэлт | 500.0 |
| **XIY** | **ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД** | **584.3** |
| **XIY.1** | **Гадаад харилцааны яам** | **584.3** |
| XIY.1.1 | Хөрөнгө оруулалт: | 364.3 |
| XIY.1.1.1 | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Элчин сайдын яамны барилга /Улаанбаатар/ | 62.1 |
| XIY.1.1.3 | Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл | 302.2 |
| XIY.1.2 | Их засвар: | 220.0 |
| XIY.1.2.1 | Гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн газруудын их засвар | 220.0 |
| **XY** | **САНГИЙН САЙД** | **2,031.5** |
| **XY.2** | **Татварын ерөнхий газар** | **1,700.6** |
| XY.2.1 | Хөрөнгө оруулалт: | 452.9 |
| XY.2.1.1 | Татварын хэлтсийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 452.9 |
| XY.2.3 | Тоног төхөөрөмж: | 1,247.7 |
| XY.2.3.1 | Цахим татвар  программ хангамж, техник, тоног төхөөрөмж худалдан авах,  сүлжээг сайжруулах /Улаанбаатар/ | 1,247.7 |
| **XY.3** | **Гаалийн ерөнхий газар** | **330.9** |
| XY.3.1 | Хөрөнгө оруулалт: | 330.9 |
| XY.3.1.3 | 8 айлын орон сууц нийт 24 айлын орон сууц 3 байршилд барих /Сүхбаатар, Бичигт; Ховд, Булган; Хөвсгөл, Мөрөн/ | 35.6 |
| XY.3.1.5 | Гаалийн албаны мэдээллийн системийг бэхжүүлэх | 68.6 |
| XY.3.1.6 | Боомтуудын ус, дулаан,  цахилгаан хангамж /Гашуунсухайт, Шивээхүрэн, Тэс, Ханги/ | 226.7 |
| **XYI** | **ХУУЛЬ ЗҮЙН САЙД** | **3,947.1** |
| **XYI.1** | **Цагдаагийн ерөнхий газар** | **1,966.8** |
| XYI.1.1 | Хөрөнгө оруулалт: | 966.8 |
| XYI.1.1.1 | Нийслэлийн цагдаагийн хэлтсийн нэгдсэн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 966.8 |
| XYI.1.3 | Тоног төхөөрөмж: | 1,000.0 |
| XYI.1.3.3 | Тусгай зориулалтын зэвсэг, техник хэрэгсэл | 1,000.0 |
| **XYI.2** | **Хил хамгаалах ерөнхий газар** | **-** |
| **XYI.3** | **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар** | **695.0** |
| XYI.3.1 | Хөрөнгө оруулалт: | 695.0 |

| | | |
|---|---|---|
| XYI.3.1.1 | Цагдан хорих байр /Увс-125.0 сая, Дундговь-368.0 сая/ | 358.1 |
| XYI.3.1.2 | Нэгдсэн хорих ангийн байр /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 336.9 |
| **XYI.6** | **Хууль зүйн яам** | **385.3** |
| XYI.6.1 | Хөрөнгө оруулалт: | 385.3 |
| XYI.6.1.2 | Дүүргийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 20.9 |
| XYI.6.1.3 | Дүүргийн шүүхийн нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 364.4 |
| **XYI.7** | **Хууль сахиулахын их сургууль** | **900.0** |
| XYI.7.1 | Хөрөнгө оруулалт: | 900.0 |
| XYI.7.1.1 | Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн байрны барилга, 3000 сонсогч /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 876.1 |
| XYI.7.1.2 | Хууль сахиулахын их сургуулийн сонсогч оюутны дотуур байр, 850 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 23.9 |
| **XYII** | **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД** | **15,507.8** |
| **XYII.1** | **Цахилгаан дамжуулах шугам, дэд станц** | **9,018.2** |
| XYII.1.3 | Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Баянхонгор/ | 400.0 |
| XYII.1.4 | Малчин-Тэс сумын 35 кВ-ын 115 км ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Увс/ | 626.9 |
| XYII.1.14 | Дархан хотын 110/6 кВ-ын Давхар дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/ | 217.7 |
| XYII.1.19 | Халиун-Цээл сумын 35 кВ-ын 31.4 км, 15 кВ-ын 84.5 км ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/ | 1,039.1 |
| XYII.1.21 | 6 кВ-ын кабелийн шинэчлэл, газар доорхи кабелийн гэмтэл илрүүлэх багаж авах /Баян-Өлгий/ | 244.6 |
| XYII.1.32 | Тайширын УЦС-ын ажиллагсдын орон сууц, конторын барилга, халаалтын зуухны хамт /Говь-Алтай/ | 219.3 |
| XYII.1.33 | Сумдын 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станцын иж бүрэн шинэчлэл | 235.0 |
| XYII.1.36 | “Сонгино” 220/110/35 кВ-ын 2х125 МВА дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/ | 3,000.0 |
| XYII.1.37 | “Их тойрог” 110 кВ-ын 97 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын 2х40 МВА дэд станц /Улаанбаатар/ | 2,413.1 |
| XYII.1.38 | Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/ | 161.7 |
| XYII.1.40 | Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /УБЦТС/ | 178.8 |

| | | |
|---|---|---|
| XYII.1.41 | Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/ | 282.0 |
| **XYII.2** | **Дулааны цахилгаан станц, дулааны шугам** | **2,328.6** |
| XYII.2.1 | Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Сүхбаатар, Баруун-Урт/ | 800.0 |
| XYII.2.9 | НС-3-ын насосуудыг хувьсах хурдны насосуудаар шинэчлэх /Улаанбаатар/ | 123.1 |
| XYII.2.17 | Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх/ | 50.2 |
| XYII.2.18 | Дулааны станцын К1, К2 зуухны засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Шарын гол/ | 64.1 |
| XYII.2.19 | Дулааны цахилгаан станц 2-ын цахилгаан тоноглолын шинэчлэл /Улаанбаатар/ | 232.0 |
| XYII.2.24 | Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх,үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур/ | 409.2 |
| XYII.2.25 | Дулааны цахилгаан станц 2-ын ТС-35-39 зуух №1, 3-д үнс барих цахилгаан шүүлтүүр суурилуулах /Улаанбаатар/ | 650.0 |
| **XYII.3** | **Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах** | **831.7** |
| XYII.3.3 | “ДЦС-4”-д зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах технологи нэвтрүүлэх /Улаанбаатар/ | 831.7 |
| **XYII.4** | **Гадаадын зээлээр хэрэгжих дотоод эх үүсвэр** | **1,500.4** |
| XYII.4.1 | ХБНГУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы ДЦС-ын техникийн шинэчлэлийн Монголын талын хөрөнгө /Дархан-Уул/ | 877.3 |
| XYII.4.3 | Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Эрчим хүчний төслийн нэмэлт санхүүжилт” төслийн дотоод эх үүсвэр | 522.3 |
| XYII.4.4 | ХБНГУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Улиастайн шугам сүлжээний төсөл”-ийн Монголын талын хөрөнгө | 100.8 |
| **XYII.5** | **Эрчим хүчний яам** | **1,828.9** |
| **XYII.5.2** | **Их засвар** | **40.0** |
| XYII.5.2.1 | Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторыг шинээр байгуулах /Улаанбаатар/ | 40.0 |
| **XYII.5.3** | **ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах** | **1,788.9** |
| XYII.5.3.1 | Хөшгийн хөндийд нисэх онгоцны буудал барихтай холбогдуулан 110 кВ-ын ЦДАШ, дэд станц барих ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Төв/ | 756.9 |
| XYII.5.3.2 | ДЦС-5-ийг Сонгино 220/110/35 кВ, Улаанбаатар 220/110/35 кВ дэд станцуудтай холбох 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ-ийн ТЭЗҮ, зураг төсөв хийх | 275.1 |
| XYII.5.3.3 | Тамсаг-Халх голын 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | 223.4 |
| XYII.5.3.7 | Аймгийн төвд шинээр барих дулааны станц, дулааны шугамын ТЭЗҮ /Говь-Алтай/ | 244.7 |

| | | |
|---|---|---|
| XYII.5.3.9 | Монгол орны нөхцөлд тохирсон нарны дулааны цахилгаан станц барих судалгаа хийх | 50.0 |
| XYII.5.3.10 | Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 220 кВ-ын 2 хэлхээт 2 ЦДАШ, дэд станцыг барих ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах | 238.8 |
| **XIX** | **ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД** | **42,007.7** |
| **XIX.1** | **Хөрөнгө оруулалт:** | **39,599.1** |
| **XIX.1.1** | **Авто зам, гүүр** | **31,560.0** |
| **XIX.1.1.1** | **Гадаад зээлээр хэрэгжүүлэх төслийн дотоод эх үүсвэр** | **4,122.4** |
| XIX.1.1.1.7 | Кувейтийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Унът-Тариалан чиглэлийн 88 км хатуу хучилттай авто зам /Булган/ | 3,955.8 |
| XIX.1.1.1.8 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Баруун бүсийн авто замыг хөгжүүлэх төсөл”. Манхан-Ховдын 85.3 км, Өлгий-Хашаатын даваа 60 км /Ховд, Баян-Өлгий/ | 31.6 |
| XIX.1.1.1.10 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл” /Дорноговь/ | 135.0 |
| **XIX.1.1.2** | **Дотоодын хөрөнгөөр баригдах авто зам** | **23,485.1** |
| XIX.1.1.2.1 | Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам /Ховд/ Үүнээс: -20 км хатуу хучилттай авто зам, -40 км замын үлдэгдэл санхүүжилт | 1,005.1 |
| XIX.1.1.2.2 | Өлгий-Цагааннуур чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий/ | 1,381.8 |
| XIX.1.1.2.4 | Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.5 км хатуу хучилттай авто зам /Завхан/ | 438.9 |
| XIX.1.1.2.5 | Сайншанд-Хамрын хийд чиглэлийн 42 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/ | 1,504.5 |
| XIX.1.1.2.6 | Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл санхүүжилт | 310.6 |
| XIX.1.1.2.9 | Элсэн тасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай замын шинэчлэл /Өвөрхангай/ | 102.7 |
| XIX.1.1.2.10 | Элсэн тасархай-Арвайхээр чиглэлийн 40 км замын хэсэгчилсэн шинэчлэл /Өвөрхангай/ | 1,414.1 |
| XIX.1.1.2.11 | Налайх /4 дүгээр зөрлөг/-Зуунмод чиглэлд 25 км хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/ | 1,080.8 |
| XIX.1.1.2.12 | Яармагийн гүүрээс Нисэхийн товчоо /1 дүгээр хэсэг/ Сонсголонгийн замын уулзвараас Яармагийн товчоо / 2 дугаар хэсэг/ хүртэлх 13.7 км авто замын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/ | 6,140.9 |
| XIX.1.1.2.14 | Доржийн гудамж, Туул жин пангийн уулзвараас зүүн тийш - Цайз зах хүртэлх 2.8 км авто замын өргөтгөл шинэчлэлт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 22 дугаар хороо/ | 632.6 |
| XIX.1.1.2.15 | Дархан-Сүхбаатар чиглэлийн авто замаас Орхон сумын төв хүртэлх 8,23 км хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/ | 174.4 |

| | | |
|---|---|---|
| XIX.1.1.2.16 | 2 км авто зам /Булган, Булган, 1 дүгээр баг/ | 25.5 |
| XIX.1.1.2.20 | Аймгийн төвийн авто замын шинэчлэл /Сүхбаатар/ | 19.0 |
| XIX.1.1.2.25 | Авто замын шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 242.7 |
| XIX.1.1.2.26 | Налайх-Агуйтийн хөтөл чиглэлийн 24.1 км замын шинэчлэл /Улаанбаатар/ | 858.0 |
| XIX.1.1.2.27 | Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км авто замын шинэчлэл /Улаанбаатар/ | 1,244.6 |
| XIX.1.1.2.29 | Бэлхийн 5 км авто замын шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 181.4 |
| XIX.1.1.2.30 | Шарга морьт-Жигжидийн уулзвараас Гүнтийн даваа чиглэлийн 5 км авто зам /Улаанбааатар/ | 219.0 |
| XIX.1.1.2.32 | Хорооллын доторх барилга, засвар, авто зам, хот тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 15.7 |
| XIX.1.1.2.34 | Ханх-Мондын чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Ханх/ | 149.4 |
| XIX.1.1.2.36 | Мянгадын гүүрээс Сархайран чиглэлд барих 20 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулж, авто замын ажил эхлүүлэх /Ховд/ | 237.4 |
| XIX.1.1.2.38 | Нисэхийн товчоо-Биокомбинат-Шувуун фабрик чиглэлийн 22.5 км авто замын өргөтгөл /Улаанбаатар/ | 68.2 |
| XIX.1.1.2.39 | 39 дүгээр сургуулийн зүүн урд талын уулзвараас Хүчит шонхор зах-эцсийн буудал хүртэлх 1.6 км авто замын өргөтгөл шинэчлэлт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 11 дүгээр хороо/ | 130.0 |
| XIX.1.1.2.40 | Баянбүрдийн тойргоос 32 тойрог хүртэлх 1.7 км авто замын шинэчлэлт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 9, 10, 11 дүгээр хороо/ | 719.2 |
| XIX.1.1.2.41 | Бэлхийн шинээр баригдсан 5 км авто замын үргэлжлэл болох 0.7 км авто замыг шинээр барих, нийт 5.7км авто замын нийт уртад гэрэлтүүлэг хийх /Улаанбаатар/ | 188.6 |
| XIX.1.1.2.46 | Өмнөх онуудад баригдсан авто замын үнийн зөрүү | 5,000.0 |
| **XIX.1.1.3** | **Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр баригдаж байгаа авто замын барилга, байгууламж** | **402.8** |
| XIX.1.1.3.1 | Арвайхээр - Баянхонгор чиглэлийн 107 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл болох 1.3 км авто зам /Өвөрхангай/ | 402.8 |
| **XIX.1.1.4** | **Авто замын сүлжээ, гүүрийн засвар, арчлалт, шинэчлэл** | **1,034.5** |
| XIX.1.1.4.5 | Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалт, шинэчлэлт | 743.3 |
| XIX.1.1.4.6 | Ховд голын 186 у/м төмөрбетон гүүрийн их засвар /Баян-Өлгий/ | 291.2 |
| **XX.1.1.5** | **Гүүр** | **2,515.2** |

| | | |
|---|---|---|
| XIX.1.1.5.4 | Үүрийн голын 326.55 у/м төмөр бетон гүүр /Хөвсгөл, Цагаан-Үүр/ | 1,566.5 |
| XIX.1.1.5.6 | Орхон голын 235.2 у/м төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Хушаат/ | 288.2 |
| XIX.1.1.5.10 | Тэсийн голын 240.26 у/м төмөр бетон гүүр /Завхан, Тэс/ | 294.2 |
| XIX.1.1.5.12 | Хүдэрийн голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Хүдэр/ | 355.0 |
| XIX.1.1.5.16 | Суман голын гүүр /Архангай, Тариат/ | 11.3 |
| **XIX.1.2** | **Тээвэр** | **8,039.1** |
| **XIX.1.2.1** | **Авто болон усан замын тээвэр** | **69.9** |
| XIX.1.2.1.6 | Нийслэл хотоос орж, гарч байгаа автозамын зам, тээврийн хяналтын цэгүүд дээр авто пүү суурилуулах /Улаанбаатар/ | 69.9 |
| **XIX.1.2.2** | **Иргэний нисэх** | **7,969.2** |
| XIX.1.2.2.5 | Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Төв, Хөшигийн хөндий/ | 7,969.2 |
| **XIX.3** | **Тоног төхөөрөмж:** | **1,950.1** |
| XIX.3.2 | Тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмж | 1,950.1 |
| **XIX.4** | **Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:** | **458.5** |
| XIX.4.1 | Шинээр баригдах зам, гүүрийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах | 441.1 |
| XIX.4.2 | Автовокзал, тээврийн хэрэгслийн оношлогооны төвийн барилга байгууламж | 17.4 |
| **XX** | **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** | **26,346.9** |
| **XX.1** | **Хөрөнгө оруулалт:** | **21,770.6** |
| XX.1.1 | Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Хот байгуулалтын салбар” төсөл /Монголын талын хөрөнгө/ | 141.6 |
| XX.1.2 | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих “Өмнөговь, Дорноговь аймгуудын хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил” төсөл /Монголын талын хөрөнгө/ | 623.5 |
| XX.1.5 | Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /улсын хэмжээнд/ | 476.8 |
| XX.1.11 | Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Дорноговь, Дорнод, Өмнөговь, Ховд, Орхон/ | 350.9 |
| XX.1.12 | Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл судлалын сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 599.4 |
| XX.1.13 | Аймаг, орон нутгийн орон сууцны инженерийн шугам сүлжээ /21 аймаг, сумдад/ | 2,040.6 |
| XX.1.25 | Тосгоны нэгдсэн халаалтын системийн барилгын ажил /Булган, Хангал, Хялганат/ | 63.7 |

| | | |
|---|---|---|
| XX.1.26 | Баянцагаан сумын халуун усны барилга, төвийн гал командын урьдах бохир усны шугам, Гурванбулаг сумын усан сан /Баянхонгор/ | 199.0 |
| XX.1.28 | Талын хашааны цэвэр, бохир усны шугам, сүлжээний өргөтгөл, их засвар /Ховд/ | 337.4 |
| XX.1.34 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Орон сууцны хороолол” төслийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 210.0 |
| XX.1.35 | Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах төслийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Гачуурт тосгон/ | 1,667.0 |
| XX.1.36 | Бүгд Найрамдах Чех Улсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцлөөр хэрэгжүүлэх “Евро Эко Төгөл” төсөл /Орхон/ | 1,000.0 |
| XX.1.37 | Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн Монголын талын хөрөнгө /Орхон, Эрдэнэт/ | 3.4 |
| XX.1.38 | Дархан хотыг “Жишиг хот” болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах | 168.6 |
| XX.1.39 | 21 аймгийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах | 53.4 |
| XX.1.40 | 2 аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх /Баян-Өлгий, Сэлэнгэ/ | 360.9 |
| XX.1.41 | Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар/ | 400.0 |
| XX.1.43 | “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх | 390.0 |
| XX.1.44 | Хаягийн мэдээллийн систем байгуулах /Улаанбаатар/ | 110.0 |
| XX.1.47 | Аймаг нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг дунд үйлдвэр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах | 892.2 |
| XX.1.48 | Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх /орон нутагт/ | 1,472.7 |
| XX.1.49 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн гол дэд бүтэц /Дархан-Уул/ | 266.5 |
| XX.1.51 | Булган хангай хорооллын дэд бүтэц, ажлыг эхлүүлэх, 240 айлын орон сууцны цэвэр, бохир усны хангамж /Архангай/ | 2.8 |
| XX.1.53 | Гэр хороололд бохир усны шугам, бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж шинээр барих /Улаанбаатар/ | 1,800.0 |
| XX.1.54 | 10 аймгийн төвийн инженерийн байгууламж, шугам сүлжээг шинэчлэх, шинээр байгуулах /Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон/ | 6,640.2 |

| | | |
|---|---|---|
| XX.1.58 | Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэл, засварын цех /Улаанбаатар/ | 1,500.0 |
| **XX.3** | **Тоног төхөөрөмж:** | **3,010.0** |
| XX.3.2 | Орон нутгийн нийтийн аж ахуйн тусгай зориулалтын машин механизм, тоног төхөөрөмж | 1,000.0 |
| XX.3.4 | Улаанбаатар хотын барилгын материалын төв лабораторийн тоног төхөөрөмж | 1,000.0 |
| XX.3.12 | Аймаг болон нийслэлийн цэвэр усны төв шугаман дээр тоолуур суурилуулах | 1,000.0 |
| XX.3.13 | Барилга, хот байгуулалтын яамны тоног төхөөрөмж | 10.0 |
| **XX.4** | **Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:** | **1,566.3** |
| XX.4.1 | Сумын дулаан, цэвэр бохир усны шугамын зураг төсөл боловсруулах /Дорнод, Халх гол/ | 74.9 |
| XX.4.3 | Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт удирдлагын системтэй дэд станцын зураг төслийг боловсруулах /Улаанбаатар/ | 213.0 |
| XX.4.7 | Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, технологийн тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн зураг төсөл боловсруулах /Сэлэнгэ, Сүхбаатар/ | 3.9 |
| XX.4.11 | Цэвэр усны 1, 3 дугаар өргөх станцын шинэчлэлт, саарал усны технологийн шугамын зураг төсөл боловсруулах /Төв, Зуунмод/ | 4.4 |
| XX.4.12 | 21 аймгийн төвийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах | 1,270.1 |
| **XXI** | **ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД** | **9,476.1** |
| **XXI.1** | **Эдийн засгийн хөгжлийн яам** | **7,910.7** |
| XXI.1.1 | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл: | 7,910.7 |
| XXI.1.1.1 | Улсын хэмжээнд 2014-2015 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах | 7,910.7 |
| **XXI.2** | **“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс** | **1,565.4** |
| XXI.2.2 | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл: | 1,565.4 |
| XXI.2.2.1 | Замын-Үүд сум, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсэд цаашид шаардагдах цэвэр усны эх үүсвэрийн хайгуул судалгаа | 949.2 |
| XXI.2.2.2 | “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн 2 дугаар ээлжийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг, төслийг боловсруулах | 616.2 |
| **XXII** | **БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД** | **21,830.7** |
| **XXII.1** | **Боловсрол** | **21,480.5** |
| XXII.1.1 | Хөрөнгө оруулалт: | 18,519.2 |

| | | |
|---|---|---|
| XXII.1.1.1 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн дотоод эх үүсвэр | 94.3 |
| XXII.1.1.2 | Япон Улсын Засгийн газрын тусламжаар хэрэгжиж байгаа “Сургуулийн барилгын өргөтгөл-4” төслийн Монголын талын хөрөнгө | 191.1 |
| XXII.1.1.3 | “Дэлхийн зөн” Олон улсын байгууллагын тусламжийн Монголын талын хөрөнгө | 205.5 |
| XXII.1.1.4 | Япон Улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө | 651.0 |
| XXII.1.1.5 | Дэлхийн банкны “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” төслийн Монголын талын хөрөнгө | 1,645.8 |
| XXII.1.1.7 | Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр/ | 450.0 |
| XXII.1.1.9 | Сургуулийн барилга, 640 суудал /Дорнод, Хэрлэн/ | 70.2 |
| XXII.1.1.10 | Сургуулийн барилга, 320 суудал /Завхан, Отгон/ | 48.0 |
| XXII.1.1.11 | Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Асгат/ | 67.2 |
| XXII.1.1.14 | Сургуулийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хархорин, Эрдэнэ-Зуу, Шашны сургууль/ | 541.7 |
| XXII.1.1.18 | Сургуулийн  барилга, 928 суудал /Дорнод, Хэрлэн, “Хан-Уул” цогцолбор/ | 318.4 |
| XXII.1.1.20 | Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Булган, Тэшиг/ | 200.0 |
| XXII.1.1.21 | Сургуулийн дотуур байрны барилга, 80 ор  /Өмнөговь, Цогт-Овоо/ | 66.0 |
| XXII.1.1.23 | Спорт заалны барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр сургууль/ | 107.5 |
| XXII.1.1.24 | Цэцэрлэгийн барилга, 175 ор  /Өмнөговь, Даланзадгад/ | 141.6 |
| XXII.1.1.28 | Их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө оруулалт | 604.2 |
| XXII.1.1.29 | “Оюутны байр-1000” хөтөлбөрийн хүрээнд 1000 оюутны байр барих /Улаанбаатар/ | 267.4 |
| XXII.1.1.30 | Их сургуулиудын хотхоны дэд бүтцийн ТЭЗҮ, зураг төсөв /Улаанбаатар, Багануур дүүрэг/ | 57.9 |
| XXII.1.1.31 | Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Архангай, Эрдэнэмандал/ | 470.9 |
| XXII.1.1.33 | Сургуулийн барилга, 640 суудал, /Булган, Булган/ | 372.6 |
| XXII.1.1.35 | Сургуулийн барилга, 960 суудал  /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 300.0 |
| XXII.1.1.38 | Сургуулийн барилгын өргөтгөл /Ховд, Чандмань/ | 135.5 |
| XXII.1.1.39 | Сургуулийн барилга /Сэлэнгэ, Сант/ | 400.0 |
| XXII.1.1.40 | Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий/ | 562.0 |
| XXII.1.1.41 | Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түмэнцогт/ | 19.0 |

| | | |
|---|---|---|
| XXII.1.1.42 | Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 400.0 |
| XXII.1.1.45 | Сургуулийн хичээлийн барилга, 120 суудал /Архангай, Цахир/ | 124.7 |
| XXII.1.1.46 | Сумын урлаг, спортын заалны барилга /Дорнод, Чойбалсан/ | 77.0 |
| XXII.1.1.49 | Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Тариалан/ | 150.0 |
| XXII.1.1.50 | Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн 2 дугаар байр/ | 522.1 |
| XXII.1.1.51 | Бага сургуулийн болон дотуур байрны барилга /Өвөрхангай, Есөнзүйл/ | 255.8 |
| XXII.1.1.55 | Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Дундговь, Сайхан-Овоо/ | 236.0 |
| XXII.1.1.60 | Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан/ | 1,099.9 |
| XXII.1.1.61 | Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал/ | 221.5 |
| XXII.1.1.62 | Спорт заалны барилга /Дорнод, Хэрлэн, 6 дугаар сургууль/ | 275.0 |
| XXII.1.1.64 | Спорт заалны барилга /Ховд, Ховд/ | 68.2 |
| XXII.1.1.66 | Спорт заалны барилга /Сэлэнгэ, Сүхбаатар, Спортын дунд сургууль/ | 150.0 |
| XXII.1.1.70 | Бага сургуулийн барилга /Өвөрхангай, Баян-Өндөр/ | 141.6 |
| XXII.1.1.71 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Өлгий, 9 дүгээр цэцэрлэг/ | 133.0 |
| XXII.1.1.72 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баянхонгор, Гурванбулаг/ | 120.3 |
| XXII.1.1.73 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Булган, Булган, 1 дүгээр цэцэрлэг/ | 199.0 |
| XXII.1.1.74 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Эрдэнэдалай/ | 475.0 |
| XXII.1.1.75 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Увс, Өмнөговь/ | 57.8 |
| XXII.1.1.76 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Алтанбулаг/ | 61.3 |
| XXII.1.1.78 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом, 4 дүгээр цэцэрлэг/ | 5.0 |
| XXII.1.1.79 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан/ | 212.5 |
| XXII.1.1.80 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар, Дулаанхаан тосгон/ | 133.3 |
| XXII.1.1.81 | Цэцэрлэгийн барилга /Ховд, Мөст/ | 240.1 |
| XXII.1.1.83 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Дорноговь, Дэлгэрэх/ | 138.1 |
| XXII.1.1.84 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Шаамар/ | 136.4 |
| XXII.1.1.85 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Жавхлант/ | 107.6 |
| XXII.1.1.86 | Спорт заалны барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн/ | 147.4 |
| XXII.1.1.88 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Эрдэнэбулган/ | 400.0 |
| XXII.1.1.91 | Сургуулийн спорт заалны барилга /Архангай, Өндөр-Улаан/ | 379.2 |

| | | |
|---|---|---|
| XXII.1.1.92 | Сургуулийн спорт заалны барилга /Архангай, Хашаат/ | 119.4 |
| XXII.1.1.94 | Сургуулийн өргөтгөл, шинэчлэлт /Сэлэнгэ, Сүхбаатар, 6 дугаар сургууль/ | 300.0 |
| XXII.1.1.95 | Цэцэрлэгийн барилга, 75 ор /Дорнод, Хөлөнбуйр/ | 241.0 |
| XXII.1.1.96 | Сургуулийн барилга, 160 суудалтай /Баян-Өлгий, Булган, Шүвтэр баг/ | 281.1 |
| XXII.1.1.97 | Сургуулийн дотуур байрны барилга /Төв, Эрдэнэсант/ | 131.4 |
| XXII.1.1.99 | Сургуулийн дотуур байрны барилга, 80 ор, /Дорноговь, Сайншанд, Төмөр замын 3 дугаар сургууль/ | 138.3 |
| XXII.1.1.103 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Сонгино/ | 73.2 |
| XXII.1.1.104 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Тосонцэнгэл/ | 602.5 |
| XXII.1.1.108 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр, 6 дугаар цэцэрлэг/ | 123.4 |
| XXII.1.1.109 | Сургуулийн байрны өргөтгөл, 320 суудал /Сүхбаатар, Баяндэлгэр/ | 259.1 |
| XXII.1.1.113 | Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Бор-Өндөр/ | 226.7 |
| XXII.1.1.114 | Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Жаргалтхаан/ | 85.4 |
| XXII.1.1.130 | Бага сургуулийн барилга /Хэнтий, Бэрх тосгон/ | 200.0 |
| XXII.1.1.131 | Спорт заалны барилга /Архангай, Булган/ | 152.0 |
| XXII.1.1.134 | Сургуулийн барилга, спорт заал 640 суудал /Орхон, Баян-Өндөр, Их залуу баг/ | 141.4 |
| XXII.1.1.136 | Сургуулийн барилга, 320 суудал /Завхан, Цагаанчулуут/ | 20.1 |
| XXII.1.1.139 | Спорт заалны барилга /Өвөрхангай, Нарийнтээл/ | 37.3 |
| XXII.1.1.140 | Спорт заалны барилга, /Дорнод, Хөлөнбуйр/ | 63.7 |
| XXII.1.1.142 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Шинэжинст/ | 315.1 |
| XXII.1.1.143 | Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Галшар/ | 83.6 |
| XXII.1.1.145 | Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хэнтий, Мөрөн/ | 218.9 |
| XXII.1.1.148 | Багшийн хөгжлийн ордны барилга / Хөвсгөл, Мөрөн/ | 50.0 |
| XXII.1.2 | Их засвар: | 438.9 |
| XXII.1.2.1 | Боловсролын салбарын их засвар | 438.9 |
| XXII.1.3 | Тоног төхөөрөмж: | 2,522.4 |
| XXII.1.3.1 | Боловсролын салбарын тоног төхөөрөмж | 2,522.4 |
| **XXII.2** | **Шинжлэх ухаан** | **350.2** |
| XXII.2.1 | Хөрөнгө оруулалт: | 52.8 |
| XXII.2.1.5 | Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий цогцолборын барилга | 52.8 |
| XXII.2.3 | Тоног төхөөрөмж: | 297.4 |
| XXII.2.3.1 | Шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж | 297.4 |

| | | |
|---|---|---|
| **XXIII** | **СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД** | **7,754.5** |
| **XXIII.1** | **Соёл** | **5,905.2** |
| XXIII.1.1 | Хөрөнгө оруулалт: | 4,613.8 |
| XXIII.1.1.3 | Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилга, 1080 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 1,000.0 |
| XXIII.1.1.5 | Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан/ | 2,000.0 |
| XXIII.1.1.7 | Соёлын төвийн барилга, 200 суудал /Баян-Өлгий, Буянт/ | 13.1 |
| XXIII.1.1.8 | Соёл, спортын төвийн барилга, 300 суудал, зуухны барилга, зам талбай /Хөвсгөл, Бүрэнтогтох/ | 23.6 |
| XXIII.1.1.10 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Сэлэнгэ, Шаамар/ | 86.7 |
| XXIII.1.1.13 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ/ | 60.4 |
| XXIII.1.1.15 | Соёлын төвийн барилга, 100 суудал /Хэнтий, Баянмөнх/ | 77.4 |
| XXIII.1.1.25 | Соёл, спортын цогцолборын барилга /Өмнөговь/ | 300.0 |
| XXIII.1.1.28 | Соёлын төвийн барилга /Өмнөговь, Гурван тэс/ | 507.0 |
| XXIII.1.1.30 | Алтай чуулгын барилга, 500 суудал /Говь-Алтай/ | 157.9 |
| XXIII.1.1.32 | Соёлын төвийн барилга /Өмнөговь, Номгон/ | 387.7 |
| XXIII.1.3 | Тоног төхөөрөмж: | 1,291.4 |
| **XXIII.2** | **СПОРТ** | **1,849.3** |
| XXIII.2.1 | Хөрөнгө оруулалт: | 1,535.3 |
| XXIII.2.1.4 | Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул/ | 955.2 |
| XXIII.2.1.5 | Спорт цогцолбор /Ховд, Манхан/ | 59.6 |
| XXIII.2.1.6 | Спорт заалны барилга /Дорнод, Хэрлэн, 2 дугаар баг/ | 68.4 |
| XXIII.2.1.8 | Хүүхэд залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай/ | 452.1 |
| XXIII.2.2 | Их засвар: | 152.0 |
| XXIII.2.3 | Тоног төхөөрөмж: | 162.0 |
| **XXIY** | **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** | **5,640.5** |
| XXIY.1 | Хөрөнгө оруулалт: | 3,286.7 |
| XXIY.1.1 | Эрүүл мэндийн төвийн барилга,100 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 489.6 |
| XXIY.1.2 | Улсын клиникийн 1 дүгээр нэгдсэн эмнэлгийн өргөтгөл /Улаанбаатар/ | 685.9 |
| XXIY.1.3 | Төрөх эмнэлэг, 50 ор /Булган, Булган/ | 27.1 |
| XXIY.1.17 | Эмнэлгийн барилга,10 ор /Говь-Алтай, Дэлгэр/ | 195.5 |
| XXIY.1.20 | Хөдөөгийн эмнэлгийн ус, ариун цэврийг сайжруулах, аюултай хог хаягдлыг устгах төсөл | 204.3 |
| XXIY.1.25 | Эмнэлгийн барилга,10 ор /Архангай, Батцэнгэл/ | 167.6 |
| XXIY.1.27 | Эрүүл мэндийг дэмжих төв /Хөвсгөл/ | 193.1 |

| | | |
|---|---|---|
| XIY.1.29 | Хүн эмнэлгийн барилга /Архангай, Тариат/ | 352.4 |
| XXIY.1.31 | Сумын эрүүл мэндийн төв, 50 ортой, /Өмнөговь, Ханбогд/ | 2.0 |
| XXIY.1.32 | Сумын эрүүл мэндийн төв, 50 ортой, /Өмнөговь, Цогтцэций/ | 969.2 |
| XXIY.2 | Их засвар: | 836.6 |
| **XXIY.2.1** | **Яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар** | **836.6** |
| XXIY.2.1.1 | Клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Улаанбаатар/ | 441.6 |
| XXIY.2.1.3 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын салхивч, дээврийн засвар | 395.0 |
| XXIY.3 | Тоног төхөөрөмж: | 1,476.1 |
| XXIY.3.3 | Хавдар судлалын үндэсний төв /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 1,240.6 |
| XXIY.3.5 | Арьсны өвчин судлалын үндэсний төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 235.5 |
| XXIY.4 | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл: | 41.1 |
| XXIY.4.2 | Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа түлэнхийн төвийн барилгын зураг төсөв | 41.1 |
| **XXY** | **ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД** | **610.1** |
| **XXY.1** | **Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам** | **610.1** |
| XXY.1.1 | Хөрөнгө оруулалт: | 610.1 |
| XXY.1.1.4 | Цахим мэдээллийн төв, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээр баригдах цахим архивтай хамтатган цогцоор шийдвэрлэх/ /Улаанбаатар/ | 610.1 |
| **XXYI** | **ХӨДӨЛМӨРИЙН САЙД** | **1,038.0** |
| **XXYI.2** | **Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл** | **1,038.0** |
| XXYI.2.1 | Хөрөнгө оруулалт: | 958.5 |
| XXYI.2.1.6 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн авто засварын дадлагын газар /Хөвсгөл/ | 172.1 |
| XXYI.2.1.7 | Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон/ | 786.4 |
| XXYI.2.3 | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл: | 79.5 |
| XXYI.2.3.1 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл | 79.5 |

| | | |
|---|---|---|
| **XXYII** | **ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД** | **6,830.0** |
| XXYII.1 | Хөрөнгө оруулалт: | 4,144.9 |
| XXYII.1.3 | Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Бүх аймагт/ | 51.3 |
| XXYII.1.6 | Түүхий эд, бүтээгдэхүүний бирж байгуулах, түүхий эдийн агуулах байгуулах /Улаанбаатар, бүх аймгуудад/ | 3,722.9 |
| XXYII.1.8 | Буянт голын услалтын систем байгуулах /Ховд/ | 370.7 |
| XXYII.2 | Их засвар | 48.3 |
| XXYII.2.1 | Мал эмнэлгийн лабораторийн засвар. /Булган, Өвөрхангай/ | 48.3 |
| XXYII.4 | ТЭЗҮ, зураг төсөл /барилга бүрээр задалж гаргана/ | 1,108.0 |
| XXYII.4.4 | Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах | 449.1 |
| XXYII.4.5 | Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор болон Багануур, Дарханы үйлдвэр технологийн паркийн захиргаа байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дорноговь, Улаанбаатар, Дархан-Уул/ | 658.9 |
| XXYII.5 | Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг | 1,528.8 |
| XXYII.5.1 | Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Булган, Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Дорнод/ | 1,480.8 |
| XXYII.5.2 | Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих, зураг төсөв боловсруулах | 48.0 |
| **XXYIII** | **БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД** | **20.0** |
| XXYIII.1 | Хөрөнгө оруулалт: | 20.0 |
| XXYIII.1.1 | Газар доорхи цэвдгийн хяналтын цооног өрөмдөж тоноглох | 20.0 |
| **XXIX** | **БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД** | **1,625.0** |
| XXIX.1 | Хөрөнгө оруулалт: | 1,625.0 |
| XXIX.1.2 | Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх | 227.5 |
| XXIX.1.7 | Цэргийн албан хаагчдын албан тушаалын 63 айлын орон сууц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 976.7 |
| XXIX.1.11 | Батлан хамгаалах их сургуулийн “Биеийн тамирын цогцолбор”-ын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 388.6 |
| XXIX.1.13 | “Шонхор хүүхдийн зуслан” төслийн соёлын төв, халуун ус /Сэлэнгэ, Мандал/ | 32.2 |

| | | |
|---|---|---|
| **XXX** | **ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** | **495.6** |
| XXX.3 | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл: | 495.6 |
| **XXXIII** | **УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР** | **509.0** |
| XXXIII.1 | Хөрөнгө оруулалт: | 277.8 |
| XXXIII.1.4 | Прокурорын байгууллагын ажилчдын орон сууцны барилга /Улаанбаатар/ | 277.8 |
| XXXIII.3 | Тоног төхөөрөмж: | 231.2 |
| XXXIII.3.2 | Тавилга, эд хогшил | 231.2 |
| | **НИЙТ ДҮН** | **155,431.4** |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр — Дугаар 28 — Улаанбаатар хот

**Хурдан морины бүсийн уралдааны 2014 оны хуваарийг тогтоох тухай**

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.3, Монголын морин спорт, уяачдын холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дүнжингарав-2014” Төвийн бүсийн хурдан морины хаврын уралдааныг 2014 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Хүй долоон худгийн Цагаан хөтөлд, хурдан морины бүсийн хаврын уралдааныг 2014 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Хангайн бүсийг Өвөрхангай аймагт, Говийн бүсийг Өмнөговь аймагт, хурдан морины бүсийн зуны уралдааныг 2014 оны 7 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Баруун бүсийг Ховд аймагт, Хангайн бүсийг Хөвсгөл аймагт, Төвийн бүсийг Дундговь аймагт, Зүүн бүсийг Дорнод аймагт, Говийн бүсийг Баянхонгор аймагт тус тус зохион байгуулахаар тогтоосугай.

2. Бүсийн хурдан морьдын уралдааныг тогтоосон хугацаанд уралдааны дүрмийн дагуу зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нар, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД — Д.ТЭРБИШДАГВА**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр — Дугаар 29 — Улаанбаатар хот

**Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 72 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төв, суурин газрын дулаан хангамжийг сайжруулах зорилтыг богино хугацаанд шийдвэрлэх, төрийн хөрөнгө оруулалтыг багасгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Архангай, Дундговь, Хэнтий аймгийн төвд шинээр дулааны станц, дулааны шугам барих төсөл, арга хэмжээ, сумдын төвлөрсөн дулаан хангамж төсөл, арга хэмжээний ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулагчийг сонгон шууд гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд М.Сономпил, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Аймгийн төвүүдэд шинээр баригдах дулааны станцын зуухны сонголтыг орон нутгийн нүүрсний шинж чанар, онцлогт тохируулан байгальд ээлтэй технологийг сонгон, станцын цаашдын найдвартай ажиллагааг хангах үүргийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд тусган хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд М.Сономпилд даалгасугай.

3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжих дээрх төслүүдийг амжилттай хэрэгжүүлж эхлүүлэх, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан холбогдох зардлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан нөхцөлөөр санхүүжүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Орон нутгийн дулаан хангамжийн системүүдийг үр ашигтай ажиллуулах, тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар болон боловсон хүчин, цалин хөлс, үнэ тарифын нэгдсэн бодлогоор хангаж,

дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрчим хүчний сайд М.Сономпил, Эрчим хүчний зохицуулах хороо (С.Отгонбаяр), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД Н.АЛТАНХУЯГ**

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД М.СОНОМПИЛ**

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 3
**Индекс: 14003**